MERIT төслийн мэдээ

2019 оны 4-р сар | Сэтгүүл №3

Баг ажиллагаа, харилцаа холбооны талаарх сургалт

2019 оны 3-р сарын 05—19

Төв, Дундговь ,Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг Даргын Тамгын Газар болон Уул уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны ажилтан, албан хаагчдад хүний нөөцийн чиглэлээр 40 жилийн ажлын туршлагатай Рональд Черлет “Багийн ажиллагаа, харилцаа холбоо”-ны талаар сургалт зохион байгууллаа. Роны хувьд багийн ажиллагаа болон үр дүнтэй харилцаа холбоогоор дамжуулан байгууллагын үр өгөөжийг дээшлүүлэх талаарх сургалтыг дэлхийн олон улс, орнуудад хүргэж ажиллаж байна. **Багийн ажиллагаа болон харилцаа холбооны үр чадвар нь 2019 оны 1-р сараас Монгол Улсын Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийг**



Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ

2019 оны 3-р сарын 03—23

Техникийн зөвлөх Реймонд Жервэйс дэлхийн тэргүүлэх хяналт шинжилгээ, үнэлгээний багийг удирддаг нэгэн билээ. Тэрээр энэ оны гуравдугаар сард Байгууллагад үр дүнд суурилсан удирдлагыг нэвтрүүлэх талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны ХШҮДАГ-ын албан хаагчдад зөвлөмж өгч ажиллаа. Тэрээр сургалт, зөвлөгөөгөөр дамжуулан багийнханд үр чадвараа хөгжүүлэхэд нь туслалцаа үзүүлсэн.



Дундговь аймагт ISO 9001: 2015 нэвтрүүлэх

2019 оны 3-р сарын 12

Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнийн 2019 оны тэргүүлэх чиглэлийн нэг нь ЗДТГ-аа ISO 9001-ийн гэрчилгээтэй болгох явдал юм. Тэрээр энэхүү зорилгодоо хүрэхэд MERIT-тэй хамтран ажиллахын тулд энэ жилийн аймгийн төсвөөс тодорхой санхүүжүүлт гаргаж буй. Төслийн Техникийн зөвлөх Мишэл Грийвэс чанарын удирдлагын чиглэлээр ажилласан 35 жилийн туршлага дээрээ үндэслэн 1-р сард **ЗДТГ-ын албан хаагчдад ISO 9001 стандартыг танилцуулсан**. Монголын зөвлөх компани болох Юнайтед менежмент консалтинг ХХК нь зөвлөхийн өгсөн зөвлөмжийн мөрөөр ажиллаж, гэрчилгээ авах явцад ажиллагсдыг залан чиглүүлэх юм. Энэ хүрээнд сумын төрийн албан хаагчдыг урьж, чанарын удирдлагын тогтолцооны талаар анхан шатны мэдлэг олгох сургалт явагдсан. Цаашлаад, тэдгээр албан хаагчид **ISO 9001 стандартыг нэвтрүүлснээр гарах байгууллагын үйл явц, журам, үйлчилгээ сайжирсны үр шимийг бэлхнээ хүртэх юм**.



Уул уурхайгаас хүртэх боломжуудын тухай

2019 оны 3-р сарын 01-нээс 4-р сарын 02

Иргэдийн амьдрал, аж ахуйд нөлөөлж буй олборлох салбарын үйл ажиллагааны талаар холбогдох мэдээллийг цаг тухайд авах болон шийдвэр гаргах явцад өөрсдийн саналаа хүргүүлэх хүсэлтэй байдаг. Энэ талаар Дорнодын Их Сургуулийн багш нар Дорнод, Сүхбаатар, Дундговь болон Төв аймгийн сумдын иргэдэд зориулан **“Уурхайн амьдралын мөчлөг”** талаар сургалт явуулах үедээ олж мэдсэн. Өнгөрсөн 10-р сард Канадын Аврора коллежийн Хөтөлбөрийн зохицуулагч, Уул уурхай, аж үйлдвэрийн сургалтын доктор Майк МакПерсон хүрэлцэн ирж Дорнод Их сургуулийн багш нарыг сургагч багшаар чадавхжуулсны үр дүнд дээрх сургалтуудыг зохион байгуулсан. **Уул уурхай, газрын тосны салбарын талаарх иргэдийн боловсролын дээшлүүлэх нь Монгол улсын засгийн газрын тэргүүлэх чиглэл болоод байгаа юм.**



Ажлын байранд жендэрийн мэдрэмжтэй хяналт шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэх нь

2019 оны 3-р сарын 20

Төв аймгийн ЗДТГ-ын ХШҮДА-ын хэлтсийн дарга Ч.Жавзанпагма болон MERIT-ийн Жендэрийн клубын гишүүд “Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт ба хяналт шинжилгээ, үнэлгээ” сэдэвт бүрэн хэмжээний сургалтыг Төв аймагт зохион байгууллаа. Сургалтын хүрээнд MERIT-ийн зөвлөхүүд болох Реймонд Жервэйс болон Миша Гофорт нар жендэрийн мэдрэмжтэй ХШҮ-г орон нутгийн жишээн дээр тайлбарлаж, төрийн захиргааны төв, орон нутгийн түнш байгууллагуудыг чадавхжуулах, **жендэрийн нүдээр харах нь оролцогчдын ажил дахь ХШҮ-ний үр нөлөөг хэрхэн сайжруулах талаарх ойлголтыг өгсөн**. Сургалтын дараа оролцогчид өөрсдийн суралцсан зүйлсээ байгууллагадаа түгээсэн төдийгүй оролцогчдоос нэг нь сурсан зүйлээ 2019 оны 3-р сарын 27-нд зохион байгуулагдсан Дорнод аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний үеэр танилцуулжээ.



Орон нутгийн ЖДҮ-ийн чадавх бэхжүүлэх

2019 оны 4-р сарын 10 –11

Төслийн Техникийн зөвлөх Эрик Карлзен 2018 оны 5-р сард Монголд анх удаа ажиллахдаа жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийн сургалтын хэрэгцээг үнэлсэн. Үүний удаах 4 томилолтын ажлаа ШУТИС-тай хамтран сургалтын хөтөлбөр боловсруулахад зориулсан. Энэ хүрээнд Дорнод, Сүхбаатар аймгийн ЖДҮ эрхлэгчдэд зориулан Дорнод их сургуультай хамтран хоёр чиглэлээр сургалт явуулж, **бизнес төлөвлөгөө боловсруулах, орон нутгийн уул уурхайн ханган нийлүүлэлтийн сүлжээнд хамрагдахад шаардлагатай санхүүжилт авахад нь дэмжлэг үзүүлсэн**. Дараагийн ээлжийн оролцогчид 10-р сарын сургалтыг тэсэн ядан хүлээж байгаа ба сургалтад хамрагдагсдын 70% нь эмэгтэй ЖДҮ эрхлэгчид байна.



БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар-15160
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж,
Нейшнл Таймс Нюсь Тауэр,
3-р давхар

info@merit.mn
www.merit.mn
+976 7016-5000

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

МЕРИТ төсөл нь **Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр** болон Канадын хоёр төрийн бус байгууллага, Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (**CESO**) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (**WUSC**) хоорондын түншлэлээр